



1991

Б Н М А У
УЛААНБААТАР ХОТЫН АРДЫН ХУРЛЫН
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРГААНЫ ТОГТООЛ

1991 оны 03 сарын 14

№ 86

Улаанбаатар хот

Дүрэм батлах тухай

Улаанбаатар хотын Ардын Хурлын Гүйцэтгэх захиргаанаас
ТОГТООХ нь:

НЭГ. Улаанбаатар хотын Ардын Хурлын Гүйцэтгэх Захиргааны
Хэрэг эрхлэх газрын дүрмийг I дүгээр хавсралтаар, Санхүүгийн
газрын дүрмийг 2 дугаар хавсралтаар, Нийгэм здийн засгийн бод-
логын зөвлөлийн дүрмийг 3 дугаар хавсралтаар, Статистик мэдээл-
лийн хэлтсийн дүрмийг 4 дүгээр хавсралтаар, Материал хангамжийн
хэлтсийн дүрмийг 5 дугаар хавсралтаар, Цэргэг иргэний хамгаалал-
тын газрын дүрмийг 6 дугаар хавсралтаар, Хеделмэд нийгэм хангам-
жийн хэлтсийн дүрмийг 7 дугаар хавсралтаар, Улаанбаатар хотын
Ардын Хурлын гүйцэтгэх захиргааны харьяа Хот байгуулалт төлөв-
лөлтийн газрын дүрмийг 8 дугаар хавсралтаар, Барилга хөрөнгө оруу-
лалтын газрын дүрмийг 9 дүгээр хавсралтаар, Хөдөө аж ахуй хүнсний
~~үйлдвэрийг~~ удицах газрын дүрмийг 10 дугаар хавсралтаар, Иргэний
гэр булийн байдлыг бүртгэх хэлтсийн дүрмийг II дүгээр хавсрал-
таар, Хууль зүйн газрын дүрмийг 12 дугаар хавсралтаар, Телефон
радио ашиглалтын хорооны дүрмийг 13 дугаар хавсралтаар, Өмчийн
газрын дүрмийг 14 дүгээр хавсралтаар, Тээврийн газрын дүрмийг 15
дугаар хавсралтаар, Боловсролын газрын дүрмийг 16 дугаар хавсрал-
таар, Соёл олон түмний ажлын хэлтсийн дүрмийг 17 дугаар хавсрал-
таар, Эзүүл мэндийн газрын дүрмийг 18 дугаар хавсралтаар, Хянан
байцах албаны дүрмийг 19 дүгээр хавсралтаар, Орон сууц нийтийн
аж ахуйг удицах газрын дүрмийг 20 дугаар хавсралтаар, Хот тохижуу-
лах газрын дүрмийг 21 дүгээр хавсралтаар, Ус сувгийн ашиглалтын
газрын дүрмийг 22 дугаар хавсралтаар, Ахуй үйлчилгээний хэлтсийн
дүрмийг 23 дугаар хавсралтаар тус тус баталсугай.

ХОЁР. Энэ дүрмууд батлагдсантай холбогдуулан Улаанбаатар хотын
Ардын хувьлын гүйцэтгэх захиргааны харьяа газар, хэлтсийн үйл ажил-
лагаанд ханалт тавьж ажиллахыг Хөвөг эрхлэх газар /ж. Ч. Сумаахуй/-т
даалгасугай.

(Ж.Ч.Сумахуй 1991-03-06 № 86-ийн хамтарч)

Ч.Сумахуй 1991-3-26-ийн 4/39/83-ийн тогтоосын
Д.Тогтолцээр давхар байгуулсан улсын
тээ хавсралтадаа, хавсралт шомжийн
хавсралтадаа дэлж

2

ГУРАВ. Энэ тогтоол гарсантай холбогдуулан хотын Архитектур төлөвлөлт зураг теслийн зохион байгуулалтын зарим арга хэмжээний тухай 1990 оны 9 дүгээр сарын 27-ны өдрийн 228 дугаар тогтоолын I дүгээр зүйлийн Архитектур төлөвлөлтийн удирдах газрын дүрмийг нагдүгээр хавсралтаар гэсэн хэсэг, "Хотын их барилга хөрөнгө оруулалтын төлөвлөлт зохион байгуулалтын зарим арга хэмжээний тухай" 1990 оны 7 дугаар сарын 22-ны өдрийн 178 дугаар тогтоолын 15 дугаар зүйл, "Хот тохижуулах газрын дүрэм батлах тухай" 1980 оны 4 дүгээр сарын 29-ний өдрийн 107 дугаар тогтоолын I дүгээр зүйл, "Нийслэлийн авто тээврийн удирдлага зохион байгуулалтыг боловсронгуй болгох зарим арга хэмжээний тухай" 1990 оны 5 дугаар сарын 22-ны өдрийн 91 дүгээр тогтоолын 2 дугаар зүйлийг тус тус хүчинтүй болсонд тооцсугай.



УЛААНБААТАР ХОТЫН АРДЫН
ХУРЛЫН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИР-
ГААНЫ ДАРГА

ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗРЫН ДАРГА

Л. ЭНЭБИН

Ч. СУМААХҮҮ

160 чи 1993 оны 2021 дахь чийг хүргүүлж

Улаанбаатар хотын Ардын Хурлын гүйцэтгэх захиргааны 1991 оны 86 дугаар тогтоолын I дүгээр хавсралтаад батлав.

УЛААНБААТАР ХОТЫН АРДЫН ХУРЛЫН ГҮЙЦЭТГЭХ
ЗАХИРГААНЫ ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗРЫН ДҮРЭМ

НЭГ. Нийтдэг үндэслэл

1. Хэрэг эрхлэх газар нь гүйцэтгэх захиргааны аштарын зохион байгуулалтын бүтцийн бие даасан нэгж мен.

2. Хэрэг эрхлэх газрын гол зорилт нь Улаанбаатар хотын Ардын Хурлын гүйцэтгэх захиргааны аппаратыг толгойлж, төр засгийн бодлого, хууль тогтоомжийг хэрэгжүүлэх, түүний биелэлтэд хяналт тавих, ажлын дотоод зохион байгуулалт, эмх цэгцийг боловсронгуй болгох, ажилтнуудад эрхалсан ажлын мэдлэг, даалгасан үүгийг хариуцах ур чадвар, бутээлч арга барил эзэмшиүүлэх, сахилга дэг журам сахиулах, тэдний нийгмийн асуудлыг хариуцаж шийдвэрлэх, хеделмерчдээс хотын Ардын Хурлын Гүйцэтгэх захиргаанд хандаж гаргасан эрэлт хүсэлтийг хулээн авч хугацаанд нь барагдуулахад оршино.

3. Хэрэг эрхлэх газар нь үйл ажиллагаандаа үндсэн хууль, аймаг хотын Ардын Хурлын тухай хууль, төрийн захиргааны зохион байгуулалтын талаар БНМАУ-ын Бага хурал, Засгийн газраас гаргасан хууль зарлиг, тогтоол, захирамж, хотын Ардын Хурлын чуулган, Тэргүүлэгчид, гүйцэтгэх захиргааны тогтоол шийдвэр болон энэ дүрмийг удирдлага болгоно.

4. Хэрэг эрхлэх газрын дарга нь хотын Ардын Хурлын чуулганаар батлагдах бөгөөд гүйцэтгэх захиргааны гишүүн байна.

5. Хэрэг эрхлэх газрын дарга нь эрх хэмжээнийхээ дотор тушаал гаргаж, түүнийхээ биелэлтийг хангуулна.

6. Хэрэг эрхлэх газар нь ахлаа жил, улирлаар төлөвлөж, гүйцэтгэлийн тайлан гаргаж байна.

Газрын ажилтны зөвлөгөөнийг улирал тутам хийж, захиргааны болон газрын ажлын төлөвлөгөө, түүний биелэлт, тогтоол шийдвэрийн хэрэгжилт, дотоод зохион байгуулалтын асуудал хэлэлцэж байна.

7. Хэрэг эрхлэх газар нь тогтоосон журмаар хийгдсэн тэмдэг, хэрэглэнэ.

2.

ХОЁР. Газрын уурэг, эрх

Хэрэг эрхлэх газар нь дор дурдсан уурэг гүйцэтгэнэ:

а/ Хотын Ардын Хурлын гүйцэтгэх захиргааны хэтийн болон жил, улирлын төлөвлөгөөг боловсруулж батлуулан гүйцэтгэлд нь хяналт тавих, үр дунг захиргааны гишүүдийн хуралд танилуулж байх;

б/ БНМАУ-ын бага хурал, засгийн газрын тогтоол, захирамж, албан даалгавар, хотын Ардын Хурлын чуулган, Тэргүүлэгчид, гүйцэтгэх захиргааны тогтоол шийдвэрийн биелэлтэд хяналт тавьж гүйцэтгэлийг шалган дүгнэж байх;

в/ Хотын Ардын Хурлын гүйцэтгэх захиргааны хуралдааныг зохион байгуулж, гаргасан шийдвэрийн биелэлтэнд хяналт тавих;

г/ Хотын Ардын Хурлын гүйцэтгэх захиргааны тайланг боловсруулах, түүнийг нийслэлийн хөдөлмөрчдөд тавьж хэлэлцуулэх ажлыг зохион байгуулах;

д/ Дүүрэг, хорооны Ардын Хурлын гүйцэтгэх захиргаа, ОСГ-ны хороо болон хөдөлмөрчдийн олон нийтийн үүсгэл санаачилгын байгууллагын ажлыг шалган зааварчлах, тэргүүний арга барилыг сурталчлан нийтийн хүртэл болгох ажлыг зохион байгуулах;

е/ Иргэдээс хотын гүйцэтгэх захиргаанд хандаж гаргасан эрэлт хүсэлтийг хүлээн авч тогтоосон журмын дагуу шуурхай шийдвэрлэх ажлыг хариуцан гүйцэтгэх;

ж/ Хотын Ардын Хурлын гүйцэтгэх захиргааны аппаратын ажлыг хөнгөн шуурхай болгох, ажилтнуудын хариуцлага, сахилга батыг дээшлүүлэхтэй холбогдсон арга хэмжээ авах;

з/ Иргэдийн шилжих хөдөлгөөний журмыг биелүүлэх ажлыг хариуцах;

и/ Хотын Ардын Хурлын гүйцэтгэх захиргааны аппаратын ажилтнууд болон дүүрэг, хороодын гүйцэтгэх захиргаа, харьяа газар, хэлтэс байгууллагуудын удирдах ажилтныг шилж сонгох санал боловсруулах, тэдгээрийн хувийн хэрэг бүртгэл судалгааг эрхлэх хетелж, онол, улс төрийн боловсрол, мэргэжлийг нь дээшлүүлэх, давтан судгах, курс семинар зөвлөлгөөнийг зохион байгуулах;

3.

- к/ Дүүрэг, хороодын Ардын Хурлын гүйцэтгэх захиргаанаас до-тоод зохион байгуулалт, иргэдтэй ажиллах талаар гаргадаг мэдээ, судалгаанд дүгнэлт егөх, нэгтгэн боловсруулж холбогдох газарт хүргүүлэх.
- л/ Аппаратын тесев санхүүг захиран зарцуулан холбогдох тайлан тооцоог хугацаанд нь үнэн зөв гаргаж байх;
- м/ Аппаратын ажилтнуудын ахуй хангамж, нийгмийн асуудлыг хариуцан шийдвэрлэж байх;
- н/ Албан байрны тохижилт, ариун цэвэр, харуул хамгаалалтыг хариуцан зохицуулж байх;
- о/ Хотын гүйцэтгэх захиргааны гадаад харилцааны асуудлыг нэгтгэн төлөвлөж шийдвэрлүүлж байх;
9. Хэрэг эрхлэх газар дор дурдсан эрх эдлэнэ.
- а/ Хотын Ардын Хурлын гүйцэтгэх захиргааны газар, хэлтэс тэдгээрийн харьяа байгууллагууд, дүүрэг хорооны гүйцэтгэх захиргаандаас төрийн дээд байгууллага болон хотын Ардын Хурлын Тэргүүлэгчид, гүйцэтгэх захиргааны шийдвэрийг хугацаанд нь чанартай биелүүлэхэд хяналт тавьж, түүнтэй холбогдох мэдээ судалгааг гаргуулан авах;
- б/ Хотын гүйцэтгэх захиргаанаас гаргах бүх шийдвэрт санал ёгч, тогтоолд хоёрдугаар гарын үсэг зурах;
- в/ Хариусан ажил ургийнхээ хүрээнд хамаарах асуудлаар хотын гүйцэтгэх захиргааны газар, хэлтэс, харьяа байгууллага, дүүрэг /хороо/-ийн гүйцэтгэх захиргааны ажлыг талган зааварчилж, шаардлагдах арга хэмжээг авах уулах;
- г/ Хотын гүйцэтгэх захиргааны тесөв болон төсвийн гадуурх хөрөнгийг зориулалтын дагуу зөв зарцуулах, тесөв санхүүгийн зөрчлөөс усьц илан сэргийлэх арга хэмжээ авах;
- д/ Газар, хэлтэс, ажилтны ажилд үнэлэлт дүгнэлт егөх, шагнаж урамшуулах, зэмлэл шийтгэл хулээлгэх саналыг боловсруулан гүйцэтгэх захиргааны удирдлагад танилцуулах;
- е/ Хууль тогтоомжийн биелэлтэд хяналт тавих зэрэг хамт олны хүчийг нэгтгэн зохион байгуулах шаардлагатай ажилд аппаратын ажилтуудыг түр хугацаагаар татан оролцуулах.

УЛААНБААТАР ХОТЫН АРДЫН ХУРЛЫН
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРГАА